



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/б/ао

Булган сум

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
хяналт шалгалт, сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.14, 17.2.16, 17.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам” 106 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” А/184 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын онцгой комиссын 2024 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар дагуу аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн гал түймэр гарах, байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа эхэлсэнтэй холбогдуулан орон нутагт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, бэлэн байдлыг хангуулах зорилгоор хяналт шалгалт, сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 23-аас 5 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалт, сургалт зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалт зохион байгуулах ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Хурандаа Ш.Баасандорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Дээрх зардалд шаардлагатай 5,000,000 (таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010372

Аймгийн Засаг даргын 20.24 оны
04 дүгээр сарын 23-ний өдрийн 1/290 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “ХЯНАЛТ ШАЛГАЛТ, СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ”-ЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Аймгийн хэмжээнд, гарч болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, орон нутагт хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, бэлтгэл бэлэн байдлыг шалган зааварчилж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, иргэд, олон нийт, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах, сайн дурын хэсэг, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах болон байгаль орчныг хамгаалах сургалт, мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Хяналт, шалгалтад аймгийн 16 сум, 1 тосгоны, Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллага, ойн нөхөрлөл, аж ахуй нэгж, иргэд хамрагдана.

Гурав.Үйл ажиллагааны чиглэл

3.1.Сургалтын арга хэмжээнд Төрийн байгууллагын ажилчдын 90-ээс багагүй хувийг, орон нутгийн иргэдийн оролцоог 250 хүнээс багагүй, байгууллагын дарга, багийн Засаг дарга нар хариуцан зохион байгуулна.

3.2.Хяналт шалгалт, сургалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль, тогтоомж, баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

3.3.Хяналт шалгалт, сургалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд шалгалт, сургалт зохион байгуулах эрх бүхий албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлж, хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

3.4.Хяналт шалгалт, сургалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэнэ.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа

4.1.Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагч дэд хурандаа Н.Хишигдорж, Гал түймрийн Улсын хяналтын ахлах байцаагч хошууч Х.Чинзориг нараар ахлуулсан Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын албан хаагчдаас бүрдсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд зохион байгуулна.

4.2.Зохион байгуулсан арга хэмжээний тайланг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, илтгэх хуудасны хамт Аймгийн Засаг даргад танилцуулна.

Тав.Үр дүн, хариуцлага

5.1.Орон нутгийн засаг захиргаа, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн гамшгаас хамгаалах чадавх, болзошгүй гамшиг осол гарсан тохиолдолд шуурхай хариу арга

хэмжээ авах бэлтгэл бэлэн байдал сайжирч, аюулгүй байдал тодорхой хэмжээгээр хангагдаж, хууль бус мод бэлтгэл, самар, ойн дагалт баялаг, ангийн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ явагдана.

5.2.Хяналт шалгалт, сургалтад хангалтгүй оролцсон Засаг даргын тамгын газар, сум болон багийн Засаг дарга, хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт холбогдох хуульд заасан хариуцлага тооцно.

---oOo---

Аймгийн Засаг даргын 2024 оны
 Нэгдүгээр сарын 23-ний өдрийн А.210 дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт

Сургалт сурталчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
 ажлын маршрут, шатахууны тооцоо

д/д	Ажиллах сум	Явах км	Шатахуун /түлш/				Томилолт	Ажиллах хоног	Ажиллах хүний тоо	Байрны зардал	Бүгд
			Тоо хэмжээ /литр/	Нэгжийн үнэ	Бүгд үнэ/төг/						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
Нэгдүгээр чиглэл											
1	Булган										
2	Сайхан	101	16.1	3650	58984	30000	1	4	40000	280000	
3	Баян-агт	72	11.5	3650	42048	30000	1	4	40000	280000	
4	Уньт	100	16	3650	58400	30000	1	4	40000	280000	
5	Хутаг-Өндөр	50	8	3650	29200	30000	1	4	40000	280000	
6	Тэшиг	103	16.5	3650	60152	30000	1	4	40000	280000	
7	Булган	250	40	3650	146000	0		4	40000	0	
8	Бугат	55	8.8	3650	32120	30000	1	4	40000	280000	
9	Сэлэнгэ	100	16	3650	58400	30000	1	4	40000	280000	
10	Хялганат	30	4.8	3650	17520	30000	1	4	40000	280000	
11	Хангал	25	4	3650	14600	30000	1	4	40000	280000	
12	Булган	100	16	3650	58400	0	0	0		0	
	Дүн	986	158		575824		9			2500000	
Хоёрдугаар чиглэл											
1	Булган										
2	Орхон	22	3.52	3650	12848	30000	1	3	40000	90000	
3	Хишиг-Өндөр	46	7.36	3650	26864	30000	1	3	40000	210000	
4	Бүрэгхангай	50	8	3650	29200	30000	1	3	40000	210000	
5	Дашинчилэн	70	11.2	3650	40880	30000	1	3	40000	210000	
6	Баяннуур	70	11.2	3650	40880	30000	1	3	40000	210000	
7	Рашаант	80	12.8	3650	46720	30000	1	3	40000	210000	
8	Гурванбулаг	75	12	3650	43800	30000	1	3	40000	210000	
9	Могод	75	12	3650	43800	30000	1	3	40000	210000	
10	Булган	135	21.6	3650	78840	0	0	0		0	
	Дүн	623	99.7		364176		7			1560000	
	Нийт дүн	1609	257		940000	0	16			4080000	
Нийт дүн											
	Томилолт, байрны зардал									4060000	
	Шатахуун									940000	
	Дүн									5000000	